

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн  
ТУЗ-ийн 2014 оны 28 сарын 15-ны өдрийн  
2014/08/15 тоот тогтоолын хавсралт



## МХБ ТӨХК-ИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

### АГУУЛГА

Бүлэг 1	Нийтлэг үндэслэл
1	Журмын зорилго
2	Журмын үйлчлэх хүрээ
3	Журамд заасан нэр томъёоны тайлбар
Бүлэг 2	Хяналт шалгалт хийх үндэслэл, журам
4	Хяналт шалгалтын ажлын чиглэл
5	Үнэт цаасны арилжаанд тавих хяналт
6	Үнэт цаасны арилжааны дэг хянах
7	Үнэт цаас гаргагч болон гишүүний гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналт
8	Өргөдөл гомдлыг шийдвэрлэх
9	Хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт
Бүлэг 3	Хяналт шалгалтын ажилтан
10	Хяналт шалгалтын ажилтны чиг үүрэг, тавигдах шаардлага
11	Хяналт шалгалтын ажилтны эрх
12	Хяналт шалгалтын ажилтны үүрэг
13	Хяналт шалгалтын ажилтанд хориглох үйл ажиллагаа
Бүлэг 4	Шалгалтын тайлан мэдээлэл
Бүлэг 5	Хариуцлага
Бүлэг 6	Бусад асуудал

# “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл. Журмын зорилго.

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зохих шалгалтыг хийх, шалгалтын дүнгээр хариуцлага ногдуулах, цаашид авах арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэн албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх, хяналт шалгалтын ажилтны эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ.

2.1. МХБ-ийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж /цаашид МХБ гэх/-ийн эрх бүхий албан тушаалтнаас баталсан журам заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэр, үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ журам болон МХБ-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан “Үнэт цаасны арилжаа зохион байгуулах заавар”, “Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар”-ыг удирдлага болгоно.

2.3. Журамд Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрснөөр МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн хурлын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулна.

2.4. Энэхүү журам нь гадаад, дотоодын үнэт цаас гаргагчдад нэгэн адил үйлчилнэ.

### 3 дугаар зүйл. Журамд орсон нэр томъёоны тайлбар.

3.1. Энэхүү журамд тусгагдсан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “Гишүүн үнэт цаасны компани”(member companies) гэж “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 48.1-д заасны дагуу МХБ-ийн гишүүний эрх авсан хуулийн этгээдийг;

3.1.2. “Арилжаанд оролцогч”(securities trading participant) гэж “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 48.1, МХБ-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын дагуу эрх авсан этгээдийг;

3.1.3. “Бусад оролцогч”(other participants) гэж хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч зэрэг гишүүн үнэт цаасны компаниас бусад үнэт цаасны зах зээлд оролцогчийг;

3.1.4. “Эрх бүхий албан тушаалтан”(governing person) гэж МХБ-ийн ТУЗ-ийн гишүүн, МХБ-ийн Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагааны газрын дарга түүнчлэн Гүйцэтгэх

захирлын шийдвэрээр хяналт шалгалт хийх эрх олгогдсон Хяналтын албаны ахлах мэргэжилтнийг (senior specialist of surveillance department);

3.1.5. “Хяналт шалгалтын ажилтан” (surveillance officer) гэж МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хяналт шалгалт хийх, үнэт цаасны арилжааны явц, үнэ ханшийн өөрчлөлтийг тусгай програмаар хянах эрх олгогдсон Хяналтын албаны мэргэжилтнийг;

3.1.6. “Гэрээ”(contract) гэж МХБ-аас Гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээг;

3.1.7. “Хяналт”(Supervision) гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.5-д заасны дагуу үнэт цаасны арилжаа зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах, аливаа бодит нөхцөл байдал нь хууль, журам, зааварт нийцэж буй эсэх, тодорхой бус зүйлийг тодорхой болгох үйл явцыг;

3.1.8. “Шалгалт”(inspection) гэж алдаа дутагдлыг илрүүлэх, засч сайжруулах, хариуцлага ногдуулахад чиглэсэн үйл явцыг;

3.1.9. “Ерөнхий хяналт”(general supervision) гэж үнэт цаасны арилжааны явцыг тусгай програмаар хянахыг;

3.1.10. “Нарийвчилсан шалгалт”(specific inspection) гэж Ерөнхий хяналтын явцад илэрсэн сэжиг бүхий хэлцэл болон үнэт цаасны арилжаа, үнэ ханштай холбоотой мэдээ мэдээллийн дагуу хийгдэх шалгалтыг;

3.1.11. “Төлөвлөгөөт шалгалт”(scheduled inspection) гэж тогтоосон хуваарийн дагуу тодорхой цаг хугацааны давтамжтайгаар гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хийх шалгалтыг;

3.1.12. “Гэнэтийн шалгалт”(unscheduled inspection) гэж иргэдийн өргөдөл, гомдол мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хэвлэлийн мэдээ, арилжаа хянах явцад илэрсэн зөрчил зэрэг цаг үеийн шаардлагаар гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд урьдчилан мэдэгдэлгүйгээр хийх шалгалтыг;

3.1.13. “Сэрэмжлүүлэх дохио”(Alert)- гэж хяналтын системээс тодорхойлсон сэжигтэй хэлцлийг;

3.1.14. “Сэжиг бүхий хэлцэл”(suspicious transaction /trade) гэж үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг үндэслэн Хяналтын албанаас тодорхойлсон зөрчилтэй байж болзошгүй хэлцлийг;

3.1.15. “Анхан шатны баримт”(primary documents) гэж захиалгын гэрээ, дилерийн даалгавар, мөнгө хүсэх өргөдөл зэрэг үнэт цаасны арилжаа, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтыг;

3.1.16. “Албан даалгавар”(official assignment) гэж Хяналтын албанаас гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдад хугацаатай үүрэг даалгавар өгч хүргүүлсэн баримт бичгийг.

## **2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ**

### **4 дүгээр зүйл. Хяналт шалгалтын ажлын чиглэл**

4.1. Хяналт шалгалтын ажлыг дараах чиглэлээр явуулна:

- 4.1.1. Үнэт цаасны арилжааны явцыг програмаар хянах;
- 4.1.2. Үнэт цаасны арилжааны дэг, ёс зүйн дүрмийн хэм хэмжээг хянах;
- 4.1.3. Гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 4.1.4. Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх.

### **5 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааны явцыг програмаар хянах**

5.1. Хяналтын алба /Millennium Surveillance/ хяналтын програмыг ашиглан өдөр бүрийн үнэт цаасны арилжааны явцад хяналт тавина.

5.1.1. Хяналтын програмаар МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын жагсаалт ба өдөр бүрийн үнэт цаасны арилжааны хэлцлийн задаргааг харах;

5.1.2. Үнэт цаасны хэлцлүүдийг графикаар харуулах, тухайн хэлцлийн худалдан авах, худалдах захиалгыг оруулсан огноо, цаг минутыг харах;

5.1.3. Хяналтын програм дээр үүссэн сэрэмжлүүлэх дохионы дагуу/Alert/ сэжигтэй хэлцлүүдийг дэлгэрүүлэн шалгаж зөрчилтэй гэж үзсэн хэлцлүүдийг цааш нарийвчлан шалгах;

5.1.4. Өдөр тутмын үнэт цаасны арилжааны явцад хувьцааны ханш хэт өссөн, буурсан хэлцэл болон цөөн тоо ширхэгээр хийгдсэн хэлцлийг харах;

5.1.5. Сэжигтэй хэлцлийн худалдан авсан, худалдсан дансны эзэмшигчид нь нэгдмэл сонирхолтой эсэхийг хянах;

5.1.6. Гишүүн үнэт цаасны компаниуд нь дилерийн даалгаварт тусгагдсан захиалгыг арилжааны програмд зөв шивж оруулсан эсэх;

5.1.7. Алсаас арилжаанд оролцох эрх бүхий гишүүн үнэт цаасны компаниуд нь тогтоосон хугацаанд цахим хэлбэрээр дилерийн даалгаврыг ирүүлж буй эсэх;

5.2. Анхдагч зах зээлийн арилжаа болон бусад төрлийн үнэт цаасны /өрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаас гэх мэт/ арилжаа явагдах тохиолдолд арилжаа хянагч нь үнэт цаас нийлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавина.

5.3. Зөрчил илэрсэн тохиолдолд журмын Тавдугаар бүлэгт заасны дагуу холбогдох арга хэмжээ авна. Шалгалтаар зөрчил илрээгүй гэж үзвэл танилцуулга бичиж, Хяналтын албаны ахлах мэргэжилтэнд танилцуулан шалгалтын ажлыг дуусгана.

## **6 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааны дэгийг хянах**

6.1. Үнэт цаасны арилжааны дэг хянах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хянана:

6.1.1. Арилжаа хөтлөгчийн үйл ажиллагаа;

6.1.2. Техник, програм хангамжийн үйл ажиллагаа;

6.1.3. Арилжаанд оролцогчдын үйл ажиллагаа, ёс зүйн дүрмийн хэм хэмжээ;

6.2. Хяналтын алба нь журмын 6.1.1, 6.1.2-д заасан үйл ажиллагаанд зөрчил дутагдал гарсан тохиолдолд түүнийг засч сайжруулах талаар арга хэмжээ авахыг холбогдох албадад мэдэгдэнэ.

6.3. Арилжаанд оролцогч нь МХБ-ийн “Үнэт цаасны арилжааг зохион байгуулах заавар”-т заасан МХБ-ийн арилжааны дэгийг баримталж байгаа эсэхэд хяналт тавина.

## **7 дугаар зүйл. Гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих**

7.1. Гишүүн үнэт цаасны компанийн дараах үйл ажиллагаанд хяналт тавина:

7.1.1. МХБ-ийн гишүүнтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт болон холбогдох бусад хууль тогтоомж журам зааврын хэрэгжилт;

7.1.2. Харилцагчийн захиалга хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаа;

7.1.3. Үнэт цаасны арилжаанд оролцогч болон дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаа;

7.1.4. “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн долдугаар бүлэгт заасан үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа явагдсан эсэх.

7.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

7.2.1. МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж байгаа эсэх;

7.2.2. Үнэт цаасны ханшид нөлөөлөх мэдээлэл олон нийтэд цаг хугацаандаа хүрч буй эсэх;

7.2.3. Үнэт цаас гаргагч нь хууль тогтоомж, журам заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх;

7.2.4. Компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж буй эсэх.

7.3. Энэ журмын 7.1, 7.2 дэх хэсгийн заалттай холбоотой анхан шатны хяналтыг Бүртгэлийн алба хэрэгжүүлнэ.

7.4. Хяналтын алба нь албадуудын анхан шатны шалгалтын дүнг төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтыг гүйцэтгэхдээ ашиглана.

## **8 дугаар зүйл. Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих**

8.1. Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэж, хариуг албан тоотоор хүргүүлнэ.

8.2. Үнэт цаас гаргагч болон гишүүн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох хяналт шалгалтыг хийж, баримт материалыг ажлын 7 хоногт гаргаж өгнө.

8.3. Үнэт цаасны арилжаа болон хувьцаатай холбоотой гомдол гаргасан иргэдтэй биечлэн уулзаж болох бөгөөд хариуг бичгээр өгнө.

8.4. Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн санал гомдол нь МХБ-ийн чиг үүрэгт хамааралгүй бол харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлж, энэ тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

8.5. Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал гомдлыг хүлээн авах, бүртгэх, хянан үзэх, шийдвэрлэхэд МХБ-ийн баталсан “Иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар”-ыг баримтална.

## **9 дүгээр зүйл. Хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт**

9.1. Хяналтын алба нь хяналт шалгалтын ажлыг дор дурдсанаар зохион байгуулна:

9.1.1. Тогтоосон хуваарь, төлөвлөсөн цаг хугацаанд батлагдсан удирдамжийн дагуу гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдад төлөвлөгөөт шалгалт хийх;

9.1.2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хэвлэлийн мэдээ, иргэдийн мэдээлэл, арилжаа хянах явцад илэрсэн зөрчил зэрэг цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд гэнэтийн шалгалт хийх.

9.2. Шалгалтын удирдамжид дараах зүйлүүдийг тодорхой тусгана. Үүнд:

- 9.2.1. Шалгалтын ажлын чиглэл;
- 9.2.2. Шалгалтын зорилго;
- 9.2.3. Шалгалт хийх хугацаа, сунгах нөхцөл;
- 9.2.4. Шалгалт явуулах бүрэлдэхүүн;
- 9.2.5. Шаардлагатай тохиолдолд бусад албадтай хамтрах тухай.

9.3. Шалгалтыг гишүүн үнэт цаасны компани болон үнэт цаас гаргагчийн ажлын байранд очиж газар дээр нь явуулж болно.

9.4. Шалгалтанд шаардлагатай баримт бичиг, тайлан мэдээллийг авч баримтын шалгалт хийнэ.

9.5. Шалгалтын удирдамжийг шалгалт эхлэхээс өмнө Гүйцэтгэх захирлаар батлуулан шалгуулах этгээдэд шалгалт эхлэхээс ажлын 3 хоногийн өмнө албан ёсоор танилцуулна.

9.6. Шалгалтыг удирдамжийн дагуу бүрэн гүйцэтгэж дууссаны дараа тайланг ажлын 3 хоногт гаргаж Хяналтын албаны ахлах мэргэжилтэнд танилцуулж, Хороонд шалгалтын удирдамжийн хамт хүргүүлнэ.

9.7. Хяналт шалгалтын үйл ажиллагааны явц болон гүйцэтгэлд Хяналтын албаны ахлах мэргэжилтэн хяналт тавина.

9.8. Шалгалтын тайлан, зөрчлийн хуудас /маягт 1/ болон бусад холбогдох материалыг шалгуулагч этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулах, хэрэв зөвшөөрөөгүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд энэ тухай тайлбарыг ажлын 3 хоногт гаргуулан авч тэмдэглэл үйлдэн Үйл ажиллагааны газрын дарга болон Гүйцэтгэх захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ. Тогтоосон хугацаанд тайлбар ирүүлээгүй тохиолдолд зөрчлийн хуудсыг хүчинтэйд тооцно.

### **3. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛТАН**

**10 дугаар зүйл. Хяналт шалгалтын ажилтны чиг үүрэг, тавигдах шаардлага**

10.1. “Millennium Surveillance” хяналтын програмд мэргэжилтнүүд бүгд ижил түвшинд хандаж арилжааны явцыг ерөнхийд нь хянана.

10.2. Үнэт цаасны арилжаа болон гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтуудыг хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.3. Хяналт шалгалтын ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна:

- 10.3.1. Эдийн засаг, банк санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүй, бизнесийн удирдлагын /аль нэг/ чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;

10.3.2. Үнэт цаасны зах зээлд гурваас доошгүй жил, МХБ-д нэгээс доошгүй жил ажилласан хяналт шалгалтын ажлын дадлага туршлагатай;

10.3.3. Ёс зүйн хувьд төлөвшсөн, сахилгын болон бусад шийтгэлгүй;

10.3.4. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхтэй, эрхийн хугацаа нь дуусгавар болоогүй.

10.4. Хяналт шалгалтын ажилтны бүрэн эрх нь хяналтын албанд үүрэг гүйцэтгэх хугацаанд хүчинтэй байна.

10.5. Хяналт шалгалтын ажилтан нь гэмт хэрэгт холбогдох, хууль хяналтын байгууллагад шалгагдах тохиолдолд бүрэн эрхийг МХБ-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар түр түдгэлзүүлэх ба хэрэв хэрэгт холбогдолгүй талаарх хуулийн байгууллагын дүгнэлт гарвал түүнийг нь үндэслэн бүрэн эрхийг сэргээнэ.

10.6. Хяналт шалгалтын ажилтан нь ажлаас чөлөөлөгдсөн болон өөр алба, хэлтэст шилжсэн тохиолдолд бүрэн эрхийг цуцлана.

10.7. Хяналт шалгалтын ажилтан нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шударга ёсыг дээдлэх, байгууллага, хувь хүний нууц, нэр төрийг хүндэтгэх зарчим баримтална.

## **11 дүгээр зүйл. Хяналт шалгалтын ажилтны эрх**

11.1. Хяналт шалгалтын ажилтан нь дараах эрхтэй байна:

11.1.1. Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай асуудлыг МХБ-ийн ТУЗ-д хэлэлцүүлэхээр оруулж танилцуулах;

11.1.2. Хяналт шалгалт хийх байгууллагад саадгүй нэвтрэн орох, шалгалтад шаардлагатай баримт материал, тайлан мэдээллийг зохих этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

11.1.3. Хяналт шалгалтын дүн, зөрчлийн хуудсыг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах талаар хугацаатай үүрэг, албан даалгавар өгөх, гүйцэтгэлийг хангуулах, холбогдох журам болон гэрээнд заасан хариуцлага ногдуулах;

11.1.4. Хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг ноцтой зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг зогсоох саналыг эрх бүхий этгээдэд гаргах;

11.1.5. Бусад алба, мэргэжилтнээс шаардлагатай мэдээ мэдээлэл гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүмүүсийг шалгалтанд татан оролцуулах, эрх бүхий байгууллагуудтай хамтран шалгалт хийх санал гаргах;

11.1.6. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаасны талаар мэдээлэл гаргуулах;

11.1.7. Хяналтын албаны ахлах мэргэжилтэн нь хяналт шалгалтын ажилтнаас шалгалтыг цаг хугацаанд нь чанартай, шуурхай явуулахыг шаардах.

## **12 дугаар зүйл. Хяналт шалгалтын ажилтны үүрэг**

12.1. Хяналт шалгалтын ажилтан нь дараах үүрэгтэй байна:

- 12.1.1. Хууль тогтоомж, журам, заавар, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах;
- 12.1.2. Шалгалтыг бодит баримт нотолгоонд үндэслэн явуулах;
- 12.1.3. Бусдын нөлөөнд автахгүй байх;
- 12.1.4. Нийтэд тараагдаагүй болон шалгалттай холбоотой мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, шалгаж буй асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргах, мэдээлэл хийх шалгалтын баримт мэдээллийг бусад зорилгоор ашиглахгүй байх;
- 12.1.5. Шалгалт нь өөрийн ашиг сонирхолд шууд хамааралтай болон шалгагдаж буй этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол энэ тухай эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, шалгалт хийхээс татгалзах;
- 12.1.6. Шалгалттай холбогдсон баримт бичиг, тайлан мэдээ, цахим тооцоолуурын файлыг зохих журмын дагуу нууцлан хадгалах;
- 12.1.7. Хяналт шалгалтын ажлын тайлан болон түүний хавсралт баримт бичиг, эд материал, мэдээ мэдээллийг анхны хэлбэрийг алдагдуулахгүйгээр тэмдэг, лац, гарын үсгээр баталгаажуулан хадгалах;
- 12.1.8. Шалгалтын эцсийн дүгнэлт, бичсэн тайлан, зааварчилгаа, сэрэмжлүүлэг, ажлын баримт, нотолгооныхоо үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 12.1.9 Шалгалтын тайлан, зөрчлийн хуудас болон бусад материалыг шалгуулагч этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулах, хэрэв зөвшөөрөөгүй буюу гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тайлбар гаргуулан авах;
- 12.1.10. Хяналт шалгалтын ажилтан нь МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэрийн дагуу олгогдсон үнэмлэхтэй байх бөгөөд тамга хэрэглэх;
- 12.1.11. Хяналт шалгалтын ажилтны үнэмлэхийг бусдад шилжүүлэхгүй байх, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх.

12.2. Хяналт шалгалтын ажилтан нь нууц хадгалах тухай гэрээг МХБ-тэй байгуулна.

### **13 дугаар зүйл. Хяналт шалгалтын ажилтанд хориглох үйл ажиллагаа**

13.1. Хяналт шалгалтын ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 13.1.1. Шалгалтын материал, баримт бичиг, мэдээ мэдээллийг бусдад зөвшөөрөлгүйгээр тараах, дамжуулах, өөр зорилгоор ашиглах;
- 13.1.2. Шалгалтанд хувийн сонирхолоор хандах, шалгуулж буй этгээдээс бэлэг, мөнгө, шагнал болон өөрт ашигтай аливаа туслалцаа авахгүй байх, ажил үүргийн хуваарьт хамаарахгүй баримт материал шаардах;
- 13.1.3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг санаатайгаар нуун дарагдуулах худал мэдээлэх;
- 13.1.4. Удирдамжид тусгагдаагүй асуудлаар шалгалт явуулах, ажилтан албан тушаалтантай зохисгүй харьцах, айлган сүрдүүлэх;
- 13.1.5. Шалгалтын талаар эцсийн дүгнэлт гараагүй байхад танилцуулах, олон нийтэд мэдээлэх, бусдын нэр хүндэд халдах;
- 13.1.6. ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасан холбогдох этгээдтэй холбоотой асуудлаар шалгалтын бүрэлдэхүүнд орох;
- 13.1.7. Удирдлагын зөвшөөрөлгүйгээр шалгалттай холбоотой материалыг гадагш гаргах.

## **4. ШАЛГАЛТЫН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ**

**14 дүгээр зүйл. Хяналт шалгалтын тайлан мэдээлэл**



14.1. Хяналт шалгалтын ажилтан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай холбоотой мэдээлэл, захиалгын гэрээ болон бусад шаардлагатай баримт ирүүлэх хугацаатай албан даалгаврыг гишүүнд өгнө.

14.2. Шалгалтын дүнгээр дараах зөрчлийг гаргасан нь тогтоогдвол хяналт шалгалтын ажилтан зөрчлийн хуудсаар энэхүү журмын 15 дугаар зүйлд заасан хариуцлагыг ногдуулна:

14.2.1. Үнэт цаасны үнэ ханш /нээлт, хаалт, дээд доод ханш/-ийг зохиомлоор тодорхой түвшинд барих, өсгөх, бууруулах үйлдэл хийсэн;

14.2.2. Үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тодорхой түвшинд барих, өсгөх, бууруулах зорилгоор үнэт цаасны арилжааны явцад цөөн тоо ширхэгээр, ханшийн өөрчлөлттэй гүйлгээг удаа дараа хийсэн;

14.2.3. Үнэ ханшид нөлөөлөх зорилгоор зах зээлтэй холбоотой худал, буруу мэдээллийг олон нийтэд тараасан;

14.2.4. Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон;

14.2.5. Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, нийтэд болон гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулсан, эрх бүхий албан тушаалтанд өгөхөөс татгалзсан, бусдын нэрийн өмнөөс өөрийн нэрийн данс болон захиран зарцуулах эрх бүхий бусад дансаар үнэт цаасны арилжаа, мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийсэн;

14.2.6. Тухайн өдрийн арилжаанд, эсвэл тодорхой хугацааны туршид хувьцааг өндөр /бага/ үнээр худалдан авсны дараа бага /өндөр/ үнээр худалдах үйлдлийг давтан үйлдсэн, ийм захиалгыг харилцагчаас хүлээн авч биелүүлсэн;

14.2.7. Биелүүлэх зорилгогүйгээр их хэмжээний захиалга шивсэн, түүнд олон дахин засвар оруулах, татаж авах, нэг захиалгыг олон хэсэг хувааж шивэх үйлдэл хийсэн;

14.2.8. Харилцагчдад худал буруу мэдээлэл өгөх, тэдгээрийг ятгах төөрөгдүүлэх, харилцагчийн захиалгыг биелүүлэхээс өмнө мэдээллийг тараах, захиалгыг орхигдуулах, харилцагчийн зөвшөөрөлгүй болон харилцагчид хохиролтой гүйлгээ хийх, захиалгын үнэ тоо ширхэгийг өөрчлөх, мөнгөн хөрөнгийг ашиглах,

14.2.9. Харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын нөхцлийг /захиалгын тоо ширхэг, үнэ, төрөл, хүчинтэй байх хугацаа/ санаатай болон болгоомжгүй байдлаар өөрчлөн системд оруулсан;

14.2.10. Арилжаанд оролцогчийн буруутай ажиллагааны улмаас захиалга өөрчлөгдсөн, эсхүл цуцлагдсан тохиолдолд журмын 15.1.1-д заасны дагуу сануулах арга хэмжээ авах, удаа дараа давтагдсан бол арилжаанд оролцогчийн эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авна;

14.2.11. Алсаас арилжаанд оролцох эрхтэй гишүүн нь системд нэвтрэх эрхээ бусдад дамжуулах болон ашиглах боломжийг санаатай буюу болгоомжгүй байдлаар олгосон;

14.2.12. Хяналт шалгалтын ажилтны албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй, арилжааны дэгийг удаа дараа зөрчсөн, анхан шатны болон санхүүгийн холбогдолтой баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй, тайлан мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаагүй;

14.2.13. Анхан шатны баримтыг буруу, дутуу хөтөлсөн, хуурамчаар бүрдүүлсэн, дилерийн даалгаварт тусгагдаагүй захиалгыг арилжааны програмд оруулсан;

14.2.14. Шалгалтын ажилд шаардлагатай баримт материал гаргаж өгөөгүй, шалгалтын ажилд саад учруулсан;

14.2.15. Арилжаа шударга явагдах нөхцөл болон харилцагчийн эрх ашгийг зөрчсөн бусад үйлдлүүд хийсэн;

14.2.16. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78, 80 дугаар зүйл болон холбогдох бусад хууль журам, дүрэм зааврыг зөрчсөн.

14.3. Хяналт шалгалтын ажилтан нь энэ журмын 14.2.1-14.2.8, 14.2.15-д заасан зөрчлийн талаар нэн даруй Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдэгдэж шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, түүний нотох баримт, танилцуулгыг хавсаргах ба Хорооны бүрэн эрхийн дагуу буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх саналаа хүргүүлж болно.

14.4. Хяналт шалгалтын ажилтан нь шалгалт хийж дууссаны дараа шалгалтын тайлан мэдээг гаргаж, Хяналтын албаны ахлах мэргэжилтэнд танилцуулна.

14.5. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол хувь хүн, хуулийн этгээдийн нууцад үл хамаарах хэсгийг олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.

14.6. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагчтай холбоотой эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

14.7. Хяналт шалгалтын ажилтан нь шалгалтын дүнгээр илэрсэн зөрчлийн талаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 74.1-т заасан дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

## **5. ХАРИУЦЛАГА**

### **15 дугаар зүйл. Хариуцлага хүлээлгэх**

15.1. Зөрчлийн хуудсыг үндэслэн гишүүн болон тэдгээрийн ажилтнуудад хариуцлага ногдуулж, дараах арга хэмжээг авна:

15.1.1. Сануулах;

15.1.2. Гэрээний хариуцлага ногдуулах;

15.1.3. Гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах;

15.1.4. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх;

15.1.5. Гишүүний эрхийг цуцлах.

15.2. Журмын 15.1.1, 15.1.3-т заасан арга хэмжээг ногдуулахаар хяналт шалгалтын ажилтны тогтоосон зөрчлийн хуудсыг МХБ-ийн Гүйцэтгэх захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

15.3. Журмын 15.2-д заасан хариуцлагыг гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой хөтөлсөн зөрчлийн тэмдэглэлийг үндэслэн ногдуулна.

15.4. Журмын 15.1.4, 15.1.5-д заасан арга хэмжээг ногдуулахаар хяналт шалгалтын ажилтны шалгаж тогтоосон зөрчлийн хуудсыг МХБ-ийн ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

15.5. Гишүүн нь хяналт шалгалтын ажилтны тогтоосон зөрчлийг хуудсыг хүлээн зөвшөөрөхгүй бол МХБ-ийн Гүйцэтгэх захиралд гомдол гаргаж болно.

15.6. МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд МХБ-ийн ТУЗ-д хандаж болно.

15.7. Хяналт шалгалтын ажилтан энэхүү журмын 11 дүгээр зүйлд заасан эрхээ хэтрүүлсэн буюу урвуулан ашигласан, 12 дугаар зүйлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй бол

МХБ-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", "Хөдөлмөрийн гэрээ"-ний дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

15.8. Үнэт цаас гаргагч нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлэхгүй, МХБ-ийн бүртгэлийн шалгуур шаардлагыг хангахгүй болох нь хяналт шалгалтаар тогтоогдвол МХБ-ийн "Бүртгэлийн журам"-д зааснаар арилжааг зогсоох, ангилал бууруулж бүртгэх, бүртгэлээс хасах арга хэмжээ авч болно. "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн холбогдох заалтыг зөрчсөн байх үндэслэлтэй бол "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-д заасан торгуулийн арга хэмжээ авахуулахаар асуудлыг Санхүүгийн Зохицуулах Хороонд шилжүүлж шийдвэрлүүлнэ.

15.9. Хяналт шалгалтаар үнэт цаас гаргагч нь МХБ-ийн "Бүртгэлийн журам"-д заасан тухайн ангиллын шаардлага хангахгүй болж МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулсан, бүртгэлээс хассан, биржийн дүрэм журмыг зөрчсөний улмаас арилжааг нь зогсоосон, хууль зөрчсөний улмаас зохих арга хэмжээ авахуулахаар Санхүүгийн Зохицуулах Хороонд шилжүүлсэн тухай МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд шуурхай мэдээлнэ.

## **6. БУСАД АСУУДАЛ**

### **16 дугаар зүйл. Бусад**

16.1. МХБ-аас үнэт цаас гаргагч болон гишүүн компанитай холбоотой гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд, уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор МХБ -ийн ТУЗ-д гомдол гаргаж болно.

16.2. МХБ-ийн ТУЗ-ийн шийдвэрийг эс зөвшөөрөх тохиолдолд, уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор эрх бүхий дээд байгууллага хандаж болно.

16.3. Энэхүү журам нь 2014 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

\*\*\*\*\*

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК  
Хяналтын алба

Улаанбаатар хот  
Огноо

ЗӨРЧЛИЙН ХУУДАС № ...

Үндэслэл

1. ....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
..... зөрчсөн болохыг тогтоов.

Шалгасан:  
Хяналт шалгалтын ажилтан:

.....  
/ /  
Тэмдэг

Зөвшөөрсөн:  
.....ҮЦК-ийн ажилтан

.....  
/ /

Танилцсан:  
.....ҮЦК-ийн захирал